131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19536.3	62791.3
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Н.Хибатай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил

зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 18-аас 2022 оны 03 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын аудитор Х.Еркебулан гүйцэтгэв.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 1/48 дугаар албан бичгээр 03 дугаар сарын 04-ний ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн болон аймаг сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлж улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлнэ” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3180.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 31.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 38.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 180.7 сая төгрөг болж, 142.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	38.7	180.7	142.0	267.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	38.7	180.7	142.0	267.0

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 180.7 сая төгрөг байгаагаас сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 47.8 сая төгрөгийн, БОХСанд 2.4 сая төгрөгийн, ЭЭСанд 5.8 сая төгрөгийн, ОНХСанд 18.8 сая төгрөгийн, СХСангийн дансанд 105.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 214.3 сая, эцсийн үлдэгдэл 146.5 сая төгрөг болж, 67.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	8.0	0.5	7.5
Төлбөртэй үйлчилгээний авлага		42.3	-42.3
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			-
Бусад авлага	0.0	0.2	-0.2
Зээлийн авлага	206.3	103.5	102.8
Дүн	214.3	146.5	67.8

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 103.5 сая төгрөг байгаа нь нийт авлагын 70.6 хувийг эзлэж, тайлант онд авлагын эргэн төлөлтөөс нэмж зээл олгоогүй байна. Зээлийн авлага 102.8 сая төгрөгөөр, Засаг даргын тамгын газрын ажиллагчидтай холбогдсон авлага 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 42.3 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, Хүүхдийн цэцэрлэг 0.2 сая төгрөгийн бусад авлага шинээр нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТШЗ-ийн тайлангаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 78.1 сая, эцсийн үлдэгдэл 102.8 сая төгрөг болж, 24.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12.8	20.9	8.1
Хангамжийн материал	65.3	81.9	16.6
Дүн	78.1	102.8	24.7

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 102.8 сая төгрөг болж 24.7 сая төгрөгөөр өссөн байна. Төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 189.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 33.1 сая төгрөгийн материал үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 190.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 7.2 сая төгрөгийг акталсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 59.4 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн, 8.2 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 22.0 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 13.2 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна. Сумын ЭМТ-ийн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсантай холбоотой материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТШЗ-ийн тайлангаар бараа материалтай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5286.1 сая, эцсийн үлдэгдэл 5395.7 сая төгрөг болж, 109.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5227.9	5333.5	105.6
Биет бус хөрөнгө	58.2	62.2	4.0
Дүн	5286.1	5395.7	109.6

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 362.7 сая төгрөг, шилжүүлэн авсан 5.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, 32.7 сая төгрөгийн хөрөнгө акталж, 6.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28.0 сая, эцсийн үлдэгдэл 33.0 сая төгрөг болж, 5.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	16.6	0.0	-16.6	0.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг				
Байгууллагад төлөх өглөг	11.4	33.0	21.6	100.0
Хувь хүмүүст төлөх өглөг				
Нийт дүн	28.0	33.0	5.0	100.0

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэлийн 33.0 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг ба ажилчидтай холбоотой өглөгийг бүрэн барагдуулсан байна.

ЭМТ-ийн ЭМДын сангаас авах авлага холбоотой 21.6 сая төгрөгийн өглөг нэмэгдэж, ЗДТГазар 0.3 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан 2.2 сая төгрөгийн, ОНХС 8.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дуусаагүй он дамжсан төсөл арга хэмжээний санхүүжилтийн олгоогүй өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТШЗ-ийн тайлангаар өглөгтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5589.9 сая, эцсийн үлдэгдэл 5792.8 сая төгрөг болж, 203.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1908.4	1908.4	0	32.9
Хуримтлагдсан үр дүн	1820.8	2023.7	202.9	35.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1860.0	1860.7	0.7	32.1
Дүн	5589.2	5792.8	203.6	100.0

Эх сурвалж: Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5792.8 сая төгрөг болж 202.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд 0.7 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна. Хуримтлагдсан үр дүн 2023.7 сая төгрөг болж 202.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5.10. Орлогын данс

Буянт сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 181.1 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 1787.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 565.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 63.9 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 62.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 8.3 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 362.7 сая төгрөгийн хөрөнгө, 33.1 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, нийтдээ 3065.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3065.0 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2650.4 сая төгрөгөөр буюу 46.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн санхүүжилт байна.

3.5.11 Зардлын данс

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2766.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 413.8 сая төгрөгөөр буюу 13.0 хувиар буурсан байна.

Нийт зардлын 96.1 хувь нь бараа үйлчилгээний зардал, 3.9 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 7.5-450.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын илрүүлэлт:

Хүүхдийн цэцэрлэг нь цалин, гэрэл цахилгаан, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, хоол хүнс, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх нийт 34.7 төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 0.1 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар гаргасан байна.

Засаг даргын тамгын газар шуудан холбоо, интернэт, бичиг хэрэг, түлш халаалт, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлын тооцоогоор гарсан нийт 33.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Ерөнхий боловсролын сургууль эмийн зардал, шуудан холбоо, интернэт, бичиг хэрэг, эм, урсгал засварын зардлын тооцоогоор гарсан нийт 2.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Сумын бусад төсөвт байгууллагуудаас тайлант онд бараа материалтай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2730.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2605.9 сая төгрөгийг урсгал зардалд, 124.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1787.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 601.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 93.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 21.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 227.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Буянт сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 2615.3 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 1784.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 609.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.6 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 93.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 106.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 106.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого 78.0 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Нийт санхүүжилтээс 4.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2515.7 сая төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Буянт сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 112.3 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 129.1 сая төгрөгөөр буюу 16.8 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 01 дүгээр хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 129.1 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 181.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 52.0 сая төгрөгөөр буюу 40.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

<i>Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>				
<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+/, бууралт /-/ /сая төгрөг/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	127.3	138.7	11.4	76.6
II.Татварын бус орлого	1.8	42.3	40.5	23.4
Нийт дүн	129.1	181.0	51.9	100.0

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 1.9 сая төгрөгөөр, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 2.3 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 1.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлогоос хүү торгуулийн орлого 2.5 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.02 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 0.2 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.2 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 18.0 сая төгрөгөөр давж, бусад нэр заагдаагүй орлогоос 36.8 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Сумын Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Мармара интернэйшнл” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ан агнуулах төлбөрөөс 103.7 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 181.0 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 47.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	64.3	64.3	-
2	Сумын ЗДТГ	354.8	353.6	1.2
3	Ерөнхий боловсролын сургууль	1,221.5	1,218.1	3.4
4	Хүүхдийн цэцэрлэг	315.6	315.6	0.0
5	Соёлын төв	73.9	71.4	2.5
6	Эрүүл мэндийн төв	392.3	392.3	-
7	ОНХСан	124.7	94.7	30.0
8	СХС	179.8	3.8	176.0
9	БОХСан	3.9	1.9	2.0
	Нийт дүн	2,730.8	2,515.7	215.1

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас нийт 62.8 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 13.6 сая, нийгмийн даатгалын шимтгэл 1.7 сая, бичиг хэрэг 0.6 сая, тээвэр шатахууны зардалд 6.0 сая, шуудан холбоо, интернэтийн төлбөр 0.1 сая, хог хаягдал зайлуулах зардалд 1.4 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 0.2 сая төгрөг, норматив зардалд 2.4 сая, томилот, зочны зардал 1.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 5.8 сая төгрөгийн, урсгал шилжүүлэг 29.4 сая төгрөг нийт 62.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт сумын Засаг дарга нь 2021 онд нийт 2515.7 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 214.4 сая 30 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2301.3 сая төгрөгийн 49 мэдээллийг хоцроосон байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 6 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын тамгын газар цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 44.0 сая төгрөгийн 3 гүйлгээ гарсныг мэдээлээгүй байна.

Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасан Төсвийн гүйцэтгэл 3 дугаар улирлын мэдээллийг "үгүй" гэж оруулсан, оны эцэст үүссэн 42.3 сая төгрөгийн авлага, 21.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

Хүүхдийн цэцэрлэг 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, таван сая төгрөгөөс дээш 102.2 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрээ байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бусад төсөвт байгууллагуудын тайлангаар шилэн данстай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Буянт сумын Засаг даргын 2021.12.08-ны 1/223 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт: №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				50%
Нийт	1		1				50%

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 5 тусгайн сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй.

1.Аудитаар 2301.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд нийт 2515.7 сая төгрөгийн 79 мэдээллийг ил тод байршуулахаас 214.4 сая 30 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2301.3 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж 59.5 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулах, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 292.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс

Засаг даргын тамгын газарт 2.9 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургуульд 1.4 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгт 108.9 сая төгрөгийн зөрчилд тус тус зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Мөн Засаг даргын тамгын газарт 77.7 сая төгрөгийн зөрчилд 2, Ерөнхий боловсролын сургуульд 2.6 сая төгрөгийн зөрчилд 1, Хүүхдийн цэцэрлэгт 34.8 сая

төгрөгийн зөрчилд 1, Эрүүл мэндийн төвд 63.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж тус тус хүргүүлээ.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын тамгын газар	3	80.6					1	2.9	2	77.7
2	Ерөнхий боловсролын сургууль	2	4.0					1	1.4	1	2.6
3	Хүүхдийн цэцэрлэг	3	143.7					2	108.9	1	34.8
4	Эрүүл мэндийн төв	1	63.9							1	63.9
Нийт дүн		9	292.2					4	113.2	5	179.0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидал тусгах алдаа зөрчил гараагүй байна. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Буянт сумын ТТЗСНТайлан	1	2301.3					1	2301.3		